



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Архивын зориулалттай барилга. 2-р хэсэг: Байгууллагын архивын өрөө,
хадгаламжийн санд тавих шаардлага**

MNS 6929-2:2021

Албан хэвлэл

**Стандарт, хэмжил зүйн газар
Улаанбаатар хот
2021 он**



ӨМНӨХ ҮГ

Стандарт, хэмжил зүйн газар нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд улсын стандартчиллын бодлогыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг юм.

Тус Газар нь тухайн салбарын үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хорооны хэлэлцэж, зөвшилцсөн стандартын төслийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Архивын ерөнхий газар, Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбооны хооронд 2020 оны 3 сарын 17-нд байгуулсан “Архивын зориулалттай өрөө тасалгаа, барилгад тавигдах шаардлага” стандарт боловсруулах ажлын гэрээ, “Архивын зориулалттай барилгын стандартын төсөл боловсруулах ажлын даалгавар”-ын дагуу Архивын ерөнхий газар, Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбооны баг боловсруулав. Багийн бүрэлдэхүүн: Д.Цэвэлмаа /Төслийн удирдагч, МБЗТЗХ-ны менежер, Монгол улсын зөвлөх архитектор/, Ч.Цэцэг /Халаалт, агаар сэлгэлтийн инженер, Монгол улсын зөвлөх инженер/, Г.Батцэнгэл /Мэдээлэл, холбоо дохиоллын инженер, Монгол улсын зөвлөх инженер/, Ж.Жаргалсайхан /Галын инженер, Монгол улсын зөвлөх инженер/, Хянан тохиолдуулсан Ш.Оюундарь /Монгол улсын зөвлөх архитектор/, Шүүмж, хяналт Т.Энхтуул /Монгол улсын зөвлөх инженер, ISO-ийн сургагч багш/.

Энэхүү стандартын төслийг Барилгын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн зөвшилцсөн болно.

СХЗГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн С/01 дүгээр тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Шуудангийн хаяг

Улаанбаатар-13343, Ш/Х - 48

Утас: 976-51-263860 Факс: 976-11-458032

E-mail: standardinform@masm.gov.mn

© СХЗГ, 2021

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 91.040.99

Архивын зориулалттай барилга. 2-р хэсэг: Байгууллагын архивын өрөө, хадгаламжийн санд тавих шаардлага	MNS 6929-2:2021
Archive buildings. Part-2: Requirements for organization's archives and saving funds.	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн С/47 дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт 2021 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

1.1 Энэ стандарт нь өмчийн хэлбэрээс үл хамааран Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд (цаашид “Байгууллага” гэх)-ийн архивын өрөө, хадгаламжийн санд тавих шаардлагыг тогтооно.

1.2 Захиргааны зориулалттай олон нийтийн барилгын зураг төсөлд байгууллагын архивын өрөө, хадгаламжийн санг төлөвлөх, өрөө тасалгааг архивын зориулалтаар шинэчлэн засварлахад мөрдөнө.

2 Норматив эшлэл

Энэхүү баримт бичигт дор дурдсан норматив баримт бичиг, стандартыг эш татаж хэрэглэсэн болно.

БНБД 20-04, Ачаалал ба үйлчлэл,

БНБД 21-01, Барилга байгууламжийн галын аюулгүй байдал,

БНБД 23-02, Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг,

БНБД 25-01, Барилгын дулаан хамгаалалт,

БНБД 31-03, Олон нийт иргэний барилга,

БНБД 31-04, Захиргааны зориулалттай олон нийтийн барилга,

БНБД 40-05, Барилга доторх ус хангамж, ариутгах татуурга,

БНБД 41-01, Халаалт агаар сэлгэлт ба кондиционер,

БД 43-101 Цахилгаан байгууламжийн дүрэм,

MNS ISO 11799, Мэдээлэл ба баримтжуулалт. Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлага,

MNS 5825, Орон сууц олон нийтийн барилга. Өрөөний бичил уур амьсгалын үзүүлэлт.

3 Ерөнхий шаардлага

3.1 Байгууллагын архив (цаашид “Архив” гэх)-ын зураг төслийг боловсруулахдаа энэхүү стандарт болон “Архивын байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм”, БНБД 31-03 Олон нийт иргэний барилга, БНБД 31-04 Захиргааны зориулалттай олон нийтийн барилга, БНБД 20-04 Ачаалал ба үйлчлэл, БНБД 21-01 Барилга байгууламжийн галын аюулгүй байдал, БНБД 25-01 Барилгын ду...



MNS 6929-2:2021

хамгаалалт, БНБД 23-02 Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг, БНБД 40-05 Барилга доторх ус хангамж, ариутгах татуурга, БНБД 41-01 Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер норм дүрэм, БД 43-101 Цахилгаан байгууламжийн дүрэм, MNS 5825 Орон сууц олон нийтийн барилга. Өрөөний бичил уур амьсгалын үзүүлэлт, MNS ISO 11799 Мэдээлэл ба баримтжуулалт. Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлага стандартыг баримтална.

3.2 Байгууллагын архив нь дараах өрөөтэй байна:

- баримт хүлээн авах өрөө;
- хадгаламжийн сан;
- архивын ажилтны өрөө;
- баримт ашиглалтын өрөө буюу уншлагын танхим.

3.3 Захиргааны зориулалттай олон нийтийн барилгын зураг төсөлд байгууллагын архивын хадгаламжийн санг заавал тусгасан байх ба барилгын адрын хонгилд болон зоорины давхарт байрлуулахыг хориглоно.

3.4 Хадгаламжийн сангийн доорх хучилтын даацыг БНБД 20-04 Ачаалал ба үйлчлэл нормд заасны дагуу тооцож төлөвлөх ба нягтруулсан шүүгээ хэрэглэх тохиолдолд 1,5-1,8 илтгэлцүүрээр үржүүлж авна.

3.5 Ашиглалтын явцад зураг төсөлд заасан өрөөнөөс өөр өрөө тасалгаанд архивын хадгаламжийн санг шилжүүлэхийг хориглоно.

3.6 Барилгын өрөө тасалгааг архивын зориулалтаар шинэчлэн засварлах тохиолдолд тус барилгын чанар, үндсэн хийцийн даац, найдвартай байдал, халаалт, агаар сэлгэлтийн системийн ажиллагаа, цахилгааны шугамын галын аюулгүй байдалд үзлэг хийж, мэргэжлийн дүгнэлт гаргасан байвал зохино. Мэргэжлийн дүгнэлт гаргах бүрэлдэхүүнд архивын, галын, барилгын, эрүүл ахуйн мэргэжилтнүүд оролцох бөгөөд тэдгээрийн дүгнэлтийг үндэслэн акт гаргасан байна.

3.7 Архивыг хуучирч муудсан барилга, модон барилга, хөгцөрч мөөгөнцөртсөн барилга, хөрсний усанд автагдсан зоорийн давхартай барилга, адрын хөндий нь чийгт цохиулж өмхөрсөн, зуухан галлагаатай барилгад байрлуулахыг хориглоно.

3.8 Архивын хадгаламжийн санг хоолны газар, хүнсний агуулах, шатах, тэсэрч дэлбэрэх, химийн бодисын агуулахтай нэг барилгад байрлуулахыг хориглоно.

3.9 Захиргааны зориулалтын 2 ба түүнээс дээш давхар барилгын давхар бүрд хадгаламжийн сан төлөвлөх тохиолдолд “Архивын зориулалттай барилгад тавих ерөнхий шаардлага MNS 6929-1:2021 стандартын 5.3-т заасныг мөрдөнө.

4 Хадгаламжийн санд тавих шаардлага

4.1 Хадгаламжийн сангийн хана (барилгын хийц бүтээц) нь гадна орчны чийг, дулааны өөрчлөлт, орчны нөлөөлөл, биологийн ба бусад сөрөг хүчин зүйлийн болзошгүй нөлөөллийг тэсвэрлэх материалаар хийгдсэн байна.



4.2 Хадгаламжийн санг тухайн барилгын сүүдэр талд, нэгдүгээр давхарт, барилгын аврах гарцад ойрхон, цайны газраас хол байрлуулна. Дээд давхраас ус алдах, доороос уур чийг цохих, гал түймрийн ослоос сэргийлж, ариун цэврийн өрөөний харалдаа доор, эсвэл зоорины давхрын дулааны узель, гараж, цахилгааны өрөөний харалдаа дээр, эсвэл дэргэд байрлуулахыг хориглоно.

4.3 Шалыг өндөр маркийн бетоноор хийж, галд тэсвэртэй будгаар будна. Шал ханын хөвөө зай завсаргүй байна.

4.4 Ханын доод хэсэг буюу гуравны хоёрыг хөгц, мөөгөнцрийн эсрэг, уур усны хамгаалалттай эмульсээр будсан байвал зохино.

4.5 Хадгаламжийн санд архивын зориулалтын тавиур шүүгээ суурилуулахад “Архивын зориулалттай барилгад тавих ерөнхий шаардлага MNS 6929-1:2021” стандартын “А хавсралт”-д заасныг мөрдөнө.

4.6 Цонхонд гэрэл бууруулагч нааж, гэрэл нэвтрэхгүй хөшиг татна.

4.7 Хадгаламжийн сангийн гэрэл нь хамгаалалтын бүрхүүлтэй байх ба 2 буюу түүнээс дээш хадгаламжийн сантай бол нэгдсэн унтраалгыг хадгаламжийн сангийн гадна байрлуулж, тус бүрт нь унтраалга хийнэ.

4.8 Баримтаас дээш 50 см-ээс дээш зайд 25 Вт-аас 40 Вт хүртэл чадалтай гэрэл байрлуулна. Архивын зориулалтын нягтруулсан шүүгээ бүхий хадгаламжийн санд энэ хэмжээ нь 30 см-ээс багагүй байна.

4.9 Байгууллагын архивын хадгаламжийн санд тохируулгатай халаах хэрэгсэл төлөвлөнө. Хадгаламжийн сангийн өрөөний температур (14-19) °C¹ хүртэл, чийгшил (50-55) % хүртэл байна.

4.10 Чийг, дулаан хэмжигчийг 100 м³ тутамд нэг байхаар тооцож байрлуулна.

5 Байгууллагын архивын өрөө тасалгааны талбай

1-р хүснэгт - Байгууллагын архивын өрөө тасалгааны талбай

д/д	Өрөө тасалгааны нэр	Архивын хүчин чадал, хадгаламжийн нэгж (х/н)	Хэмжих нэгж	Талбайн норм, м ²
1	Баримт хүлээн авах өрөө	-	-	9
2	Хадгаламжийн сан	1000	1 архивд	6
3	Архивын ажилтны өрөө	-	1 ажилтан	4
4	Баримт ашиглалтын өрөө буюу уншлагын танхим	-	-	9

¹ СХЗГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн С/01 дүгээр тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон.



6 Галын аюулгүйн шаардлага

6.1 Архивын хадгаламжийн сангийн талбай нь өрөө тус бүр 400 м²-аас бага бол хөдөлгөөнт хийн гал унтраах төхөөрөмж буюу эсвэл зөөврийн нүүрсхүчлийн хийн гал унтраагуур тоноглож болно. Ингэхдээ хадгаламжийн сангийн 50 м³ тутамд гал унтраах 1 нүүрсхүчлийн хийн гал унтраагуур тавина. Мөн гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, элс байрлуулна (элсийг 5 кг-аар зориулалтын төмөр саванд савлаж тавина).

6.2 Цахилгаан тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь цахилгаан гүйдлийн хэт ачааллаас хамгаалагдсан газардуулагчтай байх бөгөөд тэдгээрийг ашиглаж дууссаны дараа унтрааж, гүйдлээс салгана.

6.3 Цахилгаан шугам сүлжээ далд хийгдсэн байна.

6.4 Галын дохиоллыг архивын өрөө, хадгаламжийн санд төлөвлөж, дохио хүлээн авах станцыг байгууллагын жижүүрийн байранд тоноглоно.

7 Аюулгүй ажиллагаа

7.1 Архив нь байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд архивын баримтыг авран хамгаалах талаар тусган, мөрдөж ажиллана. Төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгана. Үүнд:

7.1.1 Архивын өрөө тасалгаа, хадгаламжийн сангийн байрлал, схем зураг, өрөөнд ажиллах хүний тоо, чиг үүрэг;

7.1.2 Гал, гамшгийн үед шуурхай ажиллах штаб байгуулж (байгууллагын Баримт нягтлан шалгах комиссын гишүүд байж болох), гишүүдийн хариуцах асуудал, гүйцэтгэх үүргийг тодорхойлох;

7.1.3 Гал, гамшгийн үед ажиллах тусгай үүрэг бүхий бүлгэмийг байгууллагын ажилтнуудаас оролцуулан байгуулж, гүйцэтгэх үүргийг тодорхойлох;

7.1.4 Гал, гамшгийн үед архивын баримтыг түргэн шуурхай нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө;

7.1.5 Онцгой байдлын үед холбоо барих шаардлагатай утасны жагсаалт.

8 Бусад

8.1 Архивын халаалт, агаар сэлгэлт, кондиционерийн системийг төлөвлөхөд “Архивын зориулалттай барилга, өрөө тасалгаанд тавигдах шаардлага MNS 6929-1:2021 стандартын 9-д заасныг мөрдөнө.



8.2 Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд архивын баримтыг гал, гамшиг, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, аюул ослын үед авран хамгаалах, нүүлгэн шилжүүлэх талаар тусгасан байна.

8.3 Хадгаламжийн санд модон тавиур шүүгээ, эд эдлэл ашиглахыг хориглоно.

ТӨГСӨВ.



Ном зүй

“Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай” Монгол улсын хууль
Хууль зүйн сайдын 2015 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/224 дүгээр
тушаалаар батлагдсан “Архивын байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүйн
дүрэм”

